

# ХУУРАЙ БООМТЫН ДАЛАЙН ТЭЭВЭР БОЛОН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

1

*Далайн захиргааны мэргэжилтэн Д.Байгалмаа (Ms. SC)*

# АГУУЛГА

1. Хуурай боомтын талаарх ерөнхий ойлголт
2. БНЭУ-ын хуурай боомтын хөгжил
3. БНХАУ-ын хуурай боомтын жишээ
4. Дүгнэлт

# 1. ХУУРАЙ БООМТЫН ҮҮСЭХ БОЛСОН ШАЛТГААН

- ▶ Дэлхийн эдийн засгийн өсөлт
- ▶ Бараа бүтээгдэхүүний тээврийн зардлыг бууруулах оролдлого
- ▶ Том оврын чингэлэг тээврийн хөлөг онгоцнууд шинээр бий болсон.
- ▶ Боомтын өөрчлөлт шинэчлэл хийх шаардлага:
  - a) боомтын нэвтрүүлэх хүчин чадлын хэмжээг нэмэгдүүлэх
  - b) Бараа бүтээгдэхүүнийг дамжуулан өнгөрүүлэхэд тохирохуйц хурдыг хангаж ажиллах бодит шаардлага
  - c) Орон нутгийн засаг захиргаа болон тухайн боомт бүхий бүс нутгийн оршин суугчдын эрүүл мэнд, эрүүл аюулгүй амьдрах орчныг хангах шаардлага

# ХУУРАЙ БООМТОД ТАВИГДАХ ШААРДЛАГА


➤ Хуурай боомтыг байгуулах нэгдсэн ойлголт, загвар байхгүй хэдий ч байгууламж нь дараахь шаардлагыг хангасан байна.

- Чингэлэг хадгалах
- Задгай / нурмаг ачаа
- Ерөнхий ачааны хөлгөөр ирсэн бусад ачаа

Тухайн улсын төрийн байгууллага

- Гааль
- Мэргэжлийн хяналт, Хорио цээр
- Хилийн шалган нэвтрүүлэх пост гэх мэт.

# ХУУРАЙ БООМТЫН ХУВЬСАЛ, ӨӨРЧЛӨЛТ



Functional evolution of dry ports. Source : UNESCAP (2006a).

# ХУУРАЙ БООМТЫН АНГИЛАЛ, БАЙРШИЛ

Зарим судлаачид хуурай боомтыг далайн боомтоос алслагдах

зай хэмжээгээр нь

- ▶ Богино зайн
- ▶ Дунд зайн
- ▶ Алс байрлах гэж ангилсан байна.

Эдийн засгийн ач холбогдол бүхий байршлын хувьд

- Далайн эргээс холгүй буюу далайн боомтын үргэлжлэл болгон байгуулсан (50-100 км зайд);
- Үйлдвэрлэлийн томоохон район, бүс нутгийг түшиглэн;
- Олон улсын тээврийн коридор, сүлжээ замыг тосон байгуулагдсан гэж ангилж байна.

# ХУУРАЙ БООМТОД ШААРДАГДАХ ХАТУУ ДЭД БҮТЭЦ

Хуурай боомтын тухай засгийн газар хоорондын хэлэлцээрийн Хавсралт II дугаарт хуурай боомтод тавих шаардлага дотор хатуу дэд бүтцэд хамаарах хэсэгт:

- ▶ Боомтын байршил;
- ▶ Хуурай боомт доторх дэд бүтцийн харилцан хамаарал, уялдаа холбоо болон хуурай боомтыг бусад эдийн засгийн бүстэй холбох дэд бүтцийн нөхцөл байдал
- ▶ Хуурай боомтын техникийн нөхцөл
- ▶ Чингэлэг хураах талбай болон ашиглагдах тоног төхөөрөмж
- ▶ Хуурай боомтын томоохон байгууламжийн загвар, дизайн зэргийг оруулсан байна.

# ХУУРАЙ БООМТОД ШААРДАГДАХ ЗӨӨЛӨН ДЭД БҮТЭЦ

Хуурай боомтод шаардлагатай зөөлөн дэд бүтцийн хувьд дараахь зүйлсийг дурьджээ.

- ▶ Хуурай боомтын бараа болон тоног төхөөрөмжийн урсгалыг хянаж зохицуулах мэдээллийн системийг нэвтрүүлэх
- ▶ Тухайн хуурай боомтыг олон улсын сүлжээнд таниулан, ач холбогдлыг нэмэгдүүлэхийн тулд НҮБ-ын Худалдаа болон тээврийн байршлын код UNLOCCode-ийг нэвтрүүлэх
- ▶ Олон улсын тээврийн баримт бичигт тусгуулах тал дээр санаачлагатай ажиллах
- ▶ Хуурай боомт дээр гаалийн бүрдүүлэлт хийх боломжоор хангах
- ▶ Хуурай боомтыг хөгжүүлэхэд шаардагдах хууль эрх зүйн болон бодлогын баримт бичгийг боловсруулах
- ▶ Хуурай боомтын үйл ажиллагааг хөгжүүлэх санхүүгийн оновчтой хувилбаруудтай байх шаардлагатай ажээ.



# ХУУРАЙ БООМТЫГ БАЙГУУЛСАНААР ГАРАХ ҮР ДҮН (ЭДИЙН ЗАСГИЙН ХУВЬД)

- ▶ Далайгаар тээвэрлэгдэн ирсэн бараа бүтээгдэхүүнийг дамжуулан тээвэрлэх, хадгалах боловсруулах үйл ажиллагаа нь нийт тээврийн зардлын 40-80 хувийг эзэлж байдаг (*Notteboom and Rodrigue 2005*) тул логистикийн төвийн үйл ажиллагааг сайжруулсанаар тээврийн зардал ихээхэн хэмжээгээр буурах эдийн засгийн ач холбогдолтой.
- ▶ Боомтын ачаа нэвтрүүлэх хүчин чадал нэмэгдэж эдийн засгийн үр ашиг нэмэгдэнэ.
- ▶ Хөлөг онгоцны боомт дээр дугаарлах, зангуу хаян зогсох хугацаа багассанаар үйл ажиллагааны зардал буурна, эргэлтийн хурд нэмэгдэнэ.
- ▶ Ачаа барааг тээвэрлүүлэхээр илгээсэн болон хэрэглэгч байгууллагуудын зардал хэмнэгдэж, бараа эргэлтийн хурд нэмэгдэнэ.
- ▶ Хуурай боомт хүрэх болон боомтоос бусад чиглэл рүү тээвэрлэх бусад төрлийн тээврийн хэрэгсэл (төмөр зам, авто зам)-ийн хэрэглээ нэмэгдэж, сул зогсолт, хоосон эргэлт буурна.

# ХУУРАЙ БООМТЫГ БАЙГУУЛСАНААР ГАРАХ ҮР ДҮН (нийгэм, байгаль орчны хувьд)

- ▶ Ажлын байр нэмэгдэж орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд түлхэц болно.
- ▶ Далайн тээврийн хэрэгслийн боомт орчим дугаарлан, зангуу хаяж зогсох үед үүдэн гарах агаарын бохирдол, дуу чимээ буурна.
- ▶ Далайн боомт дээрх ачаа барааг буулгах, хадгалах, боловсруулахтай холбоотой үүдэн гарах дуу чимээ, агаар болон орчны бохирдол буурна.
- ▶ Хуурай замын тээврийн хэрэгслийн оновчтой зохицуулалт бий болсоноор агаарт үүдэн гарах хорт утааны хэмжээ буурна.
- ▶ Орон нутгийн жижиг, дунд, хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоо нэмэгдэж бүс нутгийн хүмүүсийн амьдралын чанар дээшлэх боломжтой зэрэг шууд болон шууд бус нөлөөлөл эергээр үйлчилнэ.

## 2. БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС

Тус улсад хуурай боомтыг хөгжүүлсэнээр орчин үеийн боомтын үйлчилгээг үзүүлэх гол газар болж Интермодал гинжин хэлхээний үед шаардагдах бүх үйлчилгээг нэг дор үзүүлэх боломжоор хангаж байна. Үүнд:

- ▶ Ачааг цуглуулж нэгтгэх үйлчилгээ;
- ▶ Транзит ачааг ялгах;
- ▶ Ачаа бараанд гаалийн үзлэг шалгалт, холбогдох бүрдүүлэлт хийх;
- ▶ Ачааг тээвэрлэх баримт бичиг (Bill of lading)-ийг урьдчилан олгох;
- ▶ Далайн боомтын үүд хэсгийн бөөгнөрлийг бууруулах;
- ▶ Ачаа барааны бүртгэл хяналтыг сайжруулах;
- ▶ Баталгаатай агуулахад хадгалагдаж буй импортын бараа бүтээгдэхүүний татвар ногдуулах гэх мэт.

# БНЭУ-ЫН ХУУРАЙ БООМТЫН ТӨРӨЛ

- ▶ CONTAINER FREIGHT STATIONS (CFS) буюу чингэлгийн талбайг

Далайн боомтын түгжрэлийг бууруулах зорилгоор боомтын үйлчилгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэх гол цэг болгон ашиглаж авто тээврийн хэрэгслийг ашиглан бүс нутгийн төмөр замд холбогдох урсгалд нийлүүлдэг.

1 жилд – 1000TEU (2 талын эргэлт)

- ▶ INLAND CONTAINER DEPOTS (ICD) буюу Чингэлгийн гүний агуулахад

Импорт/экспортын бараа бүтээгдэхүүн бүхий чингэлгийг агуулах, хадгалах, хоосон чингэлгүүдийг цуглуулах, тухайн орон нутагт хэрэглэх бараа бүтээгдэхүүний гаалийн үзлэгийг хийх, Шууд дамжин өнгөрөх бараа бүтээгдэхүүн болон экспортод гарч буй бараа бүтээгдэхүүнийг хадгалах нийтлэг үйлчилгээ үзүүлдэг бол

1 жилд - 6000TEU (2 талын эргэлт)

# ХУУРАЙ БООМТЫН ЭЗЭМШИЛ

1989 оноос хойш БНЭУ-д 283 хуурай боомт үйл ажиллагаа явуулж байгаагаас 136 нь далайн боомттой ойролцоо байршилтай, 147 нь нутгийн гүнд байна. Эзэмшлийн ХУВЬД:

- ❑ Хувийн хэвшлийн -184
- ❑ Төв Засгийн газар болон төрийн өмчийн компанийн -99

Хуурай боомтод хөрөнгө оруулсан компани байгууллагуудын төлөөлөл, бүтцийг харвал

- ❖ Дэлхийд нэртэй далайн тээврийн томоохон компаниуд (Maersk, ULA shipping lines г.м.)
- ❖ Төв Засгийн газар болон төрийн өмчийн эзэмшлийн компаниуд Энэтхэг улсад бүртгэлтэй хувийн компаниуд
- ❖ Боомтын захиргаад
- ❖ Төмөр замын чингэлэг тээврийн операторууд (15)
- ❖ Хувийн болон Хамтарсан компаниуд байна.

# ХУУРАЙ БООМТ ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦОО

## Үйлдвэр худалдааны яам

- Хүсэлт гаргагчийн газрын асуудал болон техник эдийн засгийн үндэслэлийг хянах
- ICD/CFS-ийн ерөнхий бүтээн байгуулалтыг хянах
- Бусад худалдаа хөнгөвчлөхтэй холбоотой асуудал

## Гаалийн байгууллага

- Ачаа барааны урсгалыг хянана
- Орж ирсэн ачаанд гаалийн бүрдүүлэлт хийнэ
- Гаалийн баталгаат агуулахтай холбоотой үйл ажиллагааг хийнэ

### Авто тээврийн яам

- Авто замын бүтээн байгуулалт
- Авто тээврийн хуулийг хэрэгжүүлэх

### Төмөр замын яам

- Төмөр замаар холбох техник эдийн засгийн үндэслэл
- Төмөр замын ачаа урсгалыг хянах
- Вагоны хангамж болон бусад төмөр замын дэд бүтцийн асуудал

### Далайн тээврийн яам

- Далайгаар ирсэн бараа бүтээгдэхүүн боомтоос чөлөөтэй гарч байх
- Multimodal тээврийн хуулийг хэрэгжүүлэх
- Банк санхүүгийн институтийг байгуулах
- ICD/CFS хөгжүүлэхэд зориулан санхүүжилтийг зохицуулах
- Өдөр тутмын бусад санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой (Засгийн газрын татвар, гаалийн хураамж гэх мэт) харилцааг зохицуулах

# ТӨРИЙН ХЭВШЛИЙН ҮҮРЭГ ОРОЛЦОО

## Төрийн байгууллагын зүгээс:

- ▶ Газрын бүртгэл болон газрыг зохих ёсоор ашиглаж байгаа эсэхэд хяналт тавина.
- ▶ Тухайн боомтод шаардагдах тог, цахилгаанаар хангахад шаардагдах арга хэмжээ авах
- ▶ Хууль журам тогтоох, хөдөлмөр хамгаалал гэх мэт

## Орон нутгийн захиргаанаас:

- ▶ ICD/CFS-ээс гарах замыг гол замтай холбох
- ▶ Ус суваг болон холбогдох дэд бүтцийг холбох
- ▶ Газрын татвар болон холбогдох орон нутгийн татварыг ногдуулах, хураах



# ХУВИЙН ХЭВШЛИЙН ОРОЛЦОО

## Санхүүгийн байгууллагын зүгээс

- ▶ ICD/CFS-г хөгжүүлэх санхүүгийн асуудлаар хангах

## Бусад хувийн хэвшлийн оролцоо

- ▶ Нийтийн хоол болон бусад үйлчилгээний газрууд
- ▶ Авто замтай холбоотой тоног төхөөрөмж, бүтээн байгуулалтууд
- ▶ Худалдаа болон бизнесийн үйлчилгээ зэргийг хариуцан ажиллана.

# ХУУРАЙ БООМТ БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- ▶ Сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдах ба
  - ICD/CFS байгуулах тухай хүсэлт гаргасан материалыг боловсруулсан шаардлага болон хууль эрх зүйн хүрээнд хэлэлцэн шийдвэрлэдэг байна.
- ▶ Ажлын хэсгийн бүтцэд
  - ✓ дэд бүтэц хариуцсан нарийн бичгийн дарга нар
  - ✓ худалдааны асуудал хариуцсан захирлууд
  - ✓ авто тээвэр, төмөр зам хариуцсан захирлууд
  - ✓ Гааль болон санхүү
  - ✓ Боомт болон далайн тээвэрлэлт
  - ✓ Дэд бүтэц
  - ✓ Худалдааны асуудал хариуцсан албан тушаалтнууд

# ХУУРАЙ БООМТЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

БНЭУ-ын Гаалийн тухай 1962 оны хуулийн

- ▶ 7-р хэсэгт ICD-тэй холбоотой заалтууд
- ▶ 8-р хэсэгт гаалийн зохицуулалттай талбай
- ▶ 45.3-т
  - харуул хамгаалалт томилох тухай
  - Зардлаа нөхөх үндэслэлээр гаалийн байцаагчийг илгээх тухай
  - Гаалийн бүс дэх экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг хамгаалалтанд авах тухай хүсэлт гаргагчид тавих нөхцөл шаардлагын тухай тус, тус тусгагдсан байна.

Тус улсын авто тээврийн тухай хуульд холбогдох заалтууд орсон байдаг.

# ХОЛИМОГ ТЭЭВРИЙН ТУХАЙ 92 ОНЫ ХУУЛИЙН ЗААЛТУУД

- ▶ Тухайн үйл ажиллагаанд оролцогч нь холимог тээвэр ашиглан бизнес хийх тухай бүртгүүлэн зөвшөөрөл авсан байх;
- ▶ Хоёроос доошгүй улсад өөрийн гэсэн агент, оффистой байх;
- ▶ Далайн тээврийн үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд ачаа бараа алдагдсан гэмтсэн хариуцлагыг хүлээх чадвартай байх;
- ▶ Ачаа барааг хүлээлгэн өгснөөс хойш 9 сарын дотор гомдол барагдуулах;
- ▶ Тээвэрлэлтийн нэг л баримт бичиг гаргах ба хуурай замын тээвэрлэлтийн үед гомдол барагдуулах нөхцөл нь тодорхой бөгөөд шуурхай байх;
- ▶ Далайн тээврийн компанийн хувьд ачааны дагалдах баримт бичиг bill of lading олгосноор тээвэрлэлтийн бүх хариуцлагыг үүрэх үүрэг хүлээнэ.

# ICD/CFS БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ДЭД БҮТЭЦ

Чингэлгийн гүний агуулах (ICD) байгуулахад дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

- ▶ Оффис, конторын зориулалттай барилга байгууламж;
- ▶ гаалийн үзлэг шалгалт явуулахад шаардагдах байр, тоног төхөөрөмж;
- ▶ далайн тээврийн компани/агентын байр;
- ▶ чингэлэг хураах, хадгалах талбай;
- ▶ хүнд машин механизмд зориулсан хатуу хучилттай зам;
- ▶ экспорт, импортын бараа бүтээгдэхүүн, удаан хугацаанд хадгалагдах бараа, гаалийн баталгаат агуулахын ачаа барааг тус, тусад нь хадгалах зориулалт бүхий агуулах, склад
- ▶ Боомт руу орох болон гарах гарц нь харуул хамгаалалтаар хамгаалагдсан тусдаа байрлалтай байна.
- ▶ Боомт, терминалаар үйлчлүүлэхээр хүлээж буй автомашины хүлээлгийн зогсоол, талбай;
- ▶ Гаалийн хяналтанд зориулагдсан хилийн шугам хаалт

# ДЭД БҮТЭЦ

- ▶ Боомтын нутаг дэвсгэр дотор үйлчилгээ авахад зориулагдсан хоорондоо холбогдсон замууд
- ▶ Электрон пүү
- ▶ Хүний хэрэгцээ хангах ойр зуурын эд зүйлс (утас, факс, компьютер, ариун цэврийн өрөө, хоолны газар, уух усны хоолой гэх мэт)
- ▶ Баримт бичгийг компьютер ашиглан боловсруулахад зориулсан орчин (электрон мэдээлэл солилцох нөхцөл боломжоор хангагдсан)
- ▶ Ачаа барааг төмөр зам болон ачааны машинд ачих/буулгах, чингэлэг хураах, давхарлах, буулгахад зориулагдсан орчин үеийн тоног төхөөрөмж
- ▶ Өөр бусад төрлийн зориулалтын кран, өргөгч цамхагууд, калмаар, сэрээт өргөгч байна.

- Үйлчилгээ үзүүлж буй боомтоос төмөр зам/авто замаар авах транзит тээврийн үйл ажиллагааг хөнгөвчлөх боомт доторх болон боомтуудын хооронд үйлчлэх ачааны машин (шалаанз) / чиргүүлийн автобааз
- LCL (түүвэр ачаа) ачааг цуглуулах, тараах ажлыг зохион байгуулах агуулах
- Чингэлгийг ачилтанд бэлтгэж ариутгаж бэлтгэх талбай
- Чингэлгийг засварлах, үзлэг хяналт хийх, ариутгах
- Төмөр зам, хөдлөх бүрэлдэхүүн, хувийн хэвшлийн салаа замууд
- Чингэлэг болон ачааны байршлыг хянах тооцооллын систем
- Хүчтэй гэрэлтүүлэг бүхий аюулгүй ажиллагааны цамхагууд
- Гал унтраах тоног төхөөрөмж
- Хөлдөөгч хөргөгчийг залгах, цэнэглэх цэгүүд
- EDI систем буюу цахим мэдээлэл солилцох систем гэх мэт.

### 3. БНХАУ-ЫН ХУУРАЙ БООМТЫН ЧИГ ХАНДЛАГА

- ▶ БНХАУ хуурай боомтыг хөгжүүлэхдээ далайн тээврийн оператор компани болон орон нутгийн засаг захиргаа хамтран хувь эзэмших замаар байгуулж ашигтай ажиллаж байна. Ийм төрлийн хамтарсан компанид Хятадын үндэсний төмөр замт дэмжлэг үзүүлж хамтран ажилладаг байна. Жишээ нь:
  - ▶ Нинбо боомт: Жинхуа, Иву, Шаосин, Юутао, Чужөү гэх 5 хуурай боомтыг байгуулан 2005 оноос хойш идэвхитэй ажиллаж байгаа ба эдгээр хуурай боомтууд нь Нинбо далайн боомтыг жилд ойролцоогоор 1 сая TEU ачаагаар хангаж байна.
  - ▶ Тяньжин боомт Нинбо боомтын туршлагаас суралцаж 12 хуурай боомтыг байгуулсан бөгөөд зах зээлд нэвтрэхдээ хаалганаас хаалганд буюу door to door үйлчилгээг үзүүлдэг болжээ. Үүний үр дүнд 2005 онтой харьцуулахад тус боомтын нийт ачаа эргэлт 54.7 хувиар нэмэгдсэн.



## TOP 50 WORLD CONTAINER PORTS

Rank	Port	Volume 2016 (Million TEU)	Volume 2015 (Million TEU)	Volume 2014 (Million TEU)	Volume 2013 (Million TEU)	Volume 2012 (Million TEU)	Website
1	Shanghai, China	37.13	36.54	35.29	33.62	32.53	<a href="#">English</a> <a href="#">Chinese</a>
2	Singapore	30.90	30.92	33.87	32.60	31.65	<a href="#">English</a>
3	Shenzhen, China	23.97	24.20	24.03	23.28	22.94	<a href="#">Chinese</a>
4	Ningbo-Zhoushan, China	21.60	20.63	19.45	17.33	16.83	<a href="#">English</a> <a href="#">Chinese</a>
5	Busan, South Korea	19.85	19.45	18.65	17.69	17.04	<a href="#">English</a> <a href="#">Korean</a> <a href="#">Chinese</a> <a href="#">Japanese</a>
6	Hong Kong, S.A.R., China	19.81	20.07	22.23	22.35	23.12	<a href="#">English</a> <a href="#">Chinese</a>
7	Guangzhou Harbor, China	18.85	17.22	16.16	15.31	14.74	<a href="#">English</a> <a href="#">Chinese</a>
8	Qingdao, China	18.01	17.47	16.62	15.52	14.50	<a href="#">English</a> <a href="#">Chinese</a>
9	Jebel Ali, Dubai, United Arab Emirates	15.73	15.60	15.25	13.64	13.30	<a href="#">English</a> <a href="#">Arabic</a>
10	Tianjin, China	14.49	14.11	14.05	13.01	12.30	<a href="#">English</a> <a href="#">China</a>

## 4. Дүгнэлт

- ▶ Хөгжиж буй орнуудын хувьд хуурай боомтыг хөгжүүлэхэд хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах үйл ажиллагаа эхний үед хүндрэлтэй учраас гол гол хөрөнгө оруулалтыг засгийн газраас үндэсний хөгжлийн бодлогын хүрээнд гаргах шаардлагатай нь ажиглагдаж байна. Ялангуяа төмөр зам, авто зам гэх мэт хатуу дэд бүтцийг барьж байгуулах шаардлагатай.
- ▶ Гол төслүүдийг төрөөс санхүүжүүлэх замаар салбарт үйл ажиллагаа явуулах хувийн хэвшлийн байгууллагыг уриалан хамтарч ажиллах татан оролцуулах шаардлагатай ба төр-хувийн хэвшлийн бүрэн түншлэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь хамгийн оновчтой хувилбар болохыг эрдэмтэд дурьдсан байна. Учир нь дан ганц төрийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд ашигтай ажиллах магадлал бага, зах зээлийн уян хатан бодлого баримтлах мэдрэмж сул байдаг нь ажиглагджээ. Иймээс төр болон хувийн хэвшлийн тэнцвэртэй байдлыг хангахад чиглэгдсэн хууль, эрх зүйн орчныг бий болгох замаар хуурай боомтын төслийг амжилттай хэрэгжүүлэх боломжтой юм.